

# “БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 26-ны өдөр

№01

Улаанбаатар хот

**Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн  
гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9. дэх хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.а хэсгийн 7.8.3 дах заалт болон “Бөхөг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус удирдлага үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд тус компани өнгөрсөн онд үйл ажиллагааг эхлүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр төсөл боловсруулан, техник технологийн шинэчлэлийн судалгааг хийж, бусдад төлөх өр төлбөрийг төлөх талаар тодорхой ажлуудыг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлж ажилласныг тэмдэглэж “Бөхөг” Хувьцаат компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.ДАВААСҮРЭН

# “БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 26-ны өдөр

№02

Улаанбаатар хот

## Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.а хэсгийн 7.8.8 дахь заалт болон “Бөхөг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг **Хавсралт №1**–оор баталсугай;

2. Энэ тогтоол, тогтоолын хавсралтаар баталсан бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Даваасүрэн /-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

*[Handwritten signature]*

Б.ДАВААСҮРЭН

# “БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 26-ны өдөр

№03

Улаанбаатар хот

## Их хэмжээний хэлцэл хийх, хувьцаа нэмж гаргах асуудлаар ТУЗ-д эрх олгох эсэх тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэг, 62.1.10 дахь хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.А хэсгийн 7.7.3. дахь заалт, тус тус удирдлага болгон “Бөхөг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор компанийн нийт зарласан энгийн хувьцааны 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний энгийн хувьцааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан нэмж гаргасугай.

2. Компаниас шинээр хувьцаа гаргахтай холбоотой журмыг *Хавсралт №2*-т зааснаар баталсугай.

3. Шинээр хувьцаа нэмж гаргахтай холбоотой ажлыг эрхлэн гүйцэтгэх, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Даваасүрэн/, Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-т тус тус хариуцуулан даалгасугай.

4. Шинээр гаргаж байгаа хувьцаа, түүнтэй холбогдох бүртгэл, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, зохих бичиг баримтыг “Санхүүгийн зохицуулах хороо”, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон бусад холбогдох газруудад хуульд заасан хугацаанд, зохих журмын дагуу бүртгүүлэх, хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДАВААСҮРЭН

# “БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 26-ны өдөр

№04

Улаанбаатар хот

## Ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн тогтоолыг хэлэлцэж батлах

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дах хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.Б хэсгийн 7.32.10 дах заалтыг тус тус удирдлага болгон “Бөхөг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг судлан үзсэний үндсэн дээр Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03-р сарын 11-ний өдрийн №02 тоот тогтоолыг баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

*B. Davasuren*

Б.ДАВААСҮРЭН